

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024.04.04

Говьсүмбэр

НЭГ: УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

**Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын болон захиргааны
баримт бичгийн хэрэгжилтийн талаар**

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Мөрдөн байцаах алба, Урьдчилан сэргийлэх газраас ирүүлсэн “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2024 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэх, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх баримт бичгийн жагсаалт”-ын дагуу нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас биелэлт үр дүнг тооцож, тайлагнах бодлогын баримт бичгийн хяналтад авч, хэрэгжилтийг заасан хугацаанд тайлагнаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”, “Цагдаагийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх /код 110/ журам”-ыг тус тус баримталж, хэрэгжилтийг нэгтгэж хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх алба, нэгжид жагсаалтад заасан хугацаанд хүргүүлэн ажилласан. Бусад албад, газруудаас хугацаа зааж ирүүлсэн биелэлтийг заасан хугацаанд тайлагнан ажилласан.

Энэ хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга нараас ирүүлсэн 42 үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг тухай бүрт нь нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, нотломж үйлдэн, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хугацаатай 16 үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийн биелэлт, үр дүнг тооцож, холбогдох алба нэгжид заасан хугацаанд хүргүүлэн ажилласан.

**Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал,
тушаалын тоо**

Цагдаагийн хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар 2024 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг жилээр гарган, төлөвлөгөөний дагуу даргын зөвлөлийн хуралдааныг 3 удаа 15 асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлэн зөвлөлийн хурлын мэдээллийг нэгтгэн тухай бүр алба хаагч нарт танилцуулан ажиллав. Мөн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх санал, материалыг нэгжийн дарга нараас сар бүр авч нэгтгэн төлөвлөгөөнд тусган хэвшүүлсэн.

Цагдаагийн хэлтсийн даргын тушаал 47 гарснаас үндсэн үйл ажиллагааны чиглэлээр (“А” тушаал 12), хүний нөөцийн чиглэлээр (“Б” тушаал 35) гарган хэрэгжүүлж ажиллав.

Хүний нөөцийн бодлогын талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/135 дугаартай тушаалаар цагдаагийн хэлтсийн бүтэц, орон тоог Захиргааны удирдлагын тасаг, Эрүүгийн цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасаг, Хэрэг бүртгэх тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Замын цагдаагийн тасаг, Шивээговь сумын цагдаагийн хэсэг, сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа гэсэн бүтцэд оруулж 81 орон тоотойгоор шинэчлэн баталсан.

2020 онд бүтэц дотор шинээр Эрүүгийн цагдаагийн тасагт Экологийн асуудал

хариуцсан ахлах мөрдөгч 1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/313 дугаар тушаалаар Замын цагдаагийн зохицуулагч 1, мөн оны А/316 дугаар тушаалаар Хүүхдийн асуудал хариуцсан ахлах байцаагч 1, А/319 дугаар тушаалаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагч 1, А/06 дугаар тушаалаар сэтгэл зүйч 1, А/318 дугаар тушаалаар Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан ахлах байцаагч 1 орон тоо батлагдаж нийт 87 орон тоотойгоор үндсэн үүргээ гүйцэтгэн ажиллаж байна.

Энэ оны жилийн эцсийн байдлаар хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч 1, төлөвлөлт зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн 1, жижүүрийн мөрдөгч 1, хэсгийн төлөөлөгч 1, ахлагчийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, цагдаа зохицуулагч 1, багийн цагдаа 1, жижүүрийн цагдаа 1, нийт 8 орон тоо дутуу, 74 алба хаагч, 5 энгийн ажилтан ажил үүрэг гүйцэтгэв.

Цагдаагийн хэлтэст сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор 1 удаагийн сургалтад иргэдийг сонгон шалгаруулах зарыг хэлтсийн цахим хуудас, мэдээллийн самбар, орон нутгийн хэвлэл, мэдээ мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор 12 удаа иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулав.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-901/-д заасан сул орон тоонд тавигдах болзол шаардлага хангасан 6 иргэний материал, холбогдох судалгааг хийж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шаардлага хангасан 3 иргэний санал, материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтад хамруулан 1 иргэнийг сул орон тоонд томилуулан, 2 иргэний сургалтад хамруулав.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Албан тушаал дэвшүүлэх /код-909/”-ын дагуу болзол шаардлага хангасан, хүний нөөцийн судалгаа, алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ, ажлын үзүүлэлт, төрийн албаны мерит зарчмыг баримтлан даргын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэж 1 иргэнийг ахлагчаар, 3 ахлагчийг офицероор, 2 офицерыг ахлах, чиглэлийн ахлах болон тасгийн даргаар 2 нийт 8 алба хаагчийг тус тус цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгүүлэх саналыг хүргүүлэн шалгалтад тэнцсэн 1 иргэнийг ахлагчаар, 3 ахлагчийг офицероор томилуулах саналыг холбогдох алба нэгжид хүргүүлсэн байна.

Нийт алба хаагчдаас эрэгтэй офицер 40, эмэгтэй офицер 7, эрэгтэй ахлагч 36, эмэгтэй ахлагч 1 ажиллаж байгаа ба тэдгээрийн 68,6 хувь нь дээд боловсролтой, 20 хувь нь бүрэн дунд, 11,4 хувь нь тусгай дунд боловсролтой байна. Алба хаагчдын 43,5 хувь нь офицер, 50,4 хувь нь ахлагч, 6,1 хувь нь энгийн алба хаагчид байна. Алба хаагчдыг насны байдлаар авч үзвэл 65,8 хувь нь 35 хвртэлх насны залуучууд байна.

Тайлангийн хугацаанд чөлөө, зөвшөөрөл авсан 39 алба хаагч байгаагаас хэлтсийн даргын тушаалаар цалинтай 1, ээлжийн амралтаас 1 алба хаагч чөлөө авсан.

Шинээр томилогдсон, шилжин ирсэн 4 алба хаагчдыг албанд сургаж, дадлагажуулах халамжлан хүмүүжүүлэгч багшийг цагдаагийн хэлтсийн даргын тушаалаар томилон дасан зохицох хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулуулан танилцуулгыг даргын зөвлөлийн хурлаар 1 удаа хэлэлцүүлж, үр дүнг тооцож ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээс ирүүлсэн хамтын ажиллагаатай Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харъяа академи, их, дээд сургууль, Дотоодын хэргийн их сургуулийн эчнээ, бакалавр, энгийн дээд сургуулийн сургалтын талаарх албан бичгийг алба хаагчдад танилцуулан ажиллаж, Цагдаагийн хэлтсийн 1 алба хаагч Дотоод хэргийн их сургуулийн магистр, Хууль зүйн “Орхон” их сургуультай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд магистрын сургалтад 1,

бакалаврын сургалтад 2 алба хаагчийг тус тус суралцах боломж нөхцөлөөр хангаж ажиллав.

Алба хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор анх ажилд орсон, дэвшин томилогдсон, шилжин ирсэн алба хаагч нартай хамтарсан гэрээ байгуулан, тасаг, хэсгийн дарга нар дагалдах хуудсаар зааварчилга, зөвлөмж өгч, сар бүр дүнг тооцож хэвшүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан “Ёс зүйн” төлбөртэй сургалтад 2 алба хаагчийг хамруулав.

Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар

Цагдаагийн ерөнхий газрын тушаалаар 2024 оны “Албаны болон давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Албаны сургалтын төлөвлөгөө”-г хоёрдугаар, “Алба хаагчийн үргэлжилсэн сургалтын төлөвлөгөө”-г гуравдугаар, “Давтан, мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө”-г дөрөвдүгээр хавсралтаар баталсантай уялдуулан байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн цагдаагийн хэлтсээс 2024 онд зохион байгуулах албаны сургалтын хөтөлбөрийн хүрээнд салбар төлөвлөгөөг гарган хуваарийн дагуу албаны сургалтыг зохион байгуулан ажиллав.

Цагдаагийн хэлтсийн 2024 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд жилийн эцсийн байдлаар 11 удаагийн 15 цагийн сургалтыг батлагдсан хуваарь, удирдамжийн дагуу зохион байгуулж, давхардсан тоогоор 722 алба хаагчийг хамруулсан.

Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр мэдвэл зохих хууль тогтоомжийн 3 удаагийн 3 цагийн, Алба хаагчийг хөгжүүлэх чиглэлээр 6 удаагийн 8 цагийн, Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан 2 удаагийн 4 цагийн нийт 11 удаагийн 15 цагийн сургалтыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 722 алба хаагчдыг хамруулсан.

Аймгийн Насан туршийн боловсролын төвийн сургагч багштай хамтран алба хаагчдад 8 удаагийн 10 цагийн Монгол бичгийн сургалтыг зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газар болон харъяа албад, цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулагдсан цахим сургалт 5 удаа, аймгийн Төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад 6 удаа, ёс зүйн төлбөртэй сургалтад 1 удаа 2 алба хаагчийг тус тус хамруулжээ. Тухайлбал:

Монгол Улсын их хурлын сонгууль болохтой холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус хэлтсийн 72 алба хаагчдад 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 10.00-16.00 цагийн хооронд сургалтыг танхимаар зохион байгуулсан.

Мөн сонгуультай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр Зөрчлийн хэрэг бүртгэх албанаас зөрчил шалгаж шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад зохион байгуулсан 4 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 16 алба хаагч хамрагдсан.

Цагдаагийн ерөнхий газар болон харъяа албад, цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулагдсан сургалтуудад 2, Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээс 2023 оны 01 дүгээр сарын 06-ний өдөр зохион байгуулсан Go Smart ХХК-ний цахим сургалтын цогц платформийг ашиглах, сургалтын модулийг системд оруулах цахим сургалтанд 1 алба хаагч хамрагдсан.

Алба хаагчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр цагдаагийн хэлтсийн 3 алба хаагчийг Дорноговь аймгийн цагдаагийн газарт 2 хоногийн хугацаатай туршлага судлуулах ажлыг зохион байгуулсан.

Соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, түүний үр дүнгийн талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн А/73 дугаар “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2024 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд тус цагдаагийн газраас хэрэгжүүлэх ажлыу 21 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн төлөвлөгөөг тасаг, хэсэгт хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Тус цагдаагийн хэлтсээс 2024 онд хууль тогтоомж, төрийн болон байгууллагын бодлого чиглэл, үйл ажиллагаатай холбоотой бусад албан бичгийг 17 удаа давхардсан тоогоор 1224 алба хаагчдад танилцуулсан, түүхэн замнал, шинжлэх ухаан, техник, технологийн ололтын талаарх мэдээлэл 3 удаа хийж нийт 220 алба хаагч хамрагдсан, соёл гоо зүйн хүмүүжил, мэдлэгийг дээшлүүлэх талаар 3 удаа арга хэмжээ зохион байгуулж 219 алба хаагч хамрагдсан, биеийн тамир спортын 2 төрлийн арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор нийт 141 алба хаагч оролцсон.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, удирдлагуудаас ирүүлж байгаа үүрэг, ажлын чиглэл, алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг алба хаагчдад сурталчлан таниулах, ойлгуулах чиглэлээр 2 удаа мэдээлэл, ярилцлага хийж, байгууллагын дотоод нууцлалтай “ГСА цагдаагийн хэлтэс” хаалттай цахим группт тухай бүр байршуулан алба хаагчдад мэдээлэл хүргэж, ажилласан.

Аймгийн Боржигин чуулгатай хамтран алба хаагчдын ажлын байрны стресс, бухимдлыг арилгах, соёл гоо зүйн мэдрэмжийг дээшлүүлэх чиглэлээр Хөгжим ангийн 1 цагийн урлагийн тоглолтыг үзүүлж сонирхуулсан. Мөн аймгийн нийтийн Номын сан, Боржигин өв музейг үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Биеийн тамир спортын арга хэмжээ зохион байгуулах” код-941 журмын 941.6-д заасан биеийн тамир, спортын хамтлагын үйл ажиллагаа эрчимжүүлж, Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагаас 2024 онд зохион байгуулагдах 2 төрлийн спортын аварга шалгаруулах тэмцээний төрөл хариуцах эрх бүхий албан тушаалтаны хуваарь, дотооддоо зохион байгуулах 8 тэмцээний хуваарийг байгууллагын даргаар батлуулан хэрэгжүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагуудын дунд зохион байгуулагдсан 2024 оны “Хүндийг өргөлтийн тэмцээн”-д алба хаагчдыг амжилттай оролцуулж, цагдаа жолооч, цагдаагийн дэд ахлагч Н.Алтангэрэл суултын төрөлд дэд байранд шалгарсан амжилт үзүүлсэн.

Мөн аймаг орон нутгаас санаачилсан бусад арга хэмжээ, тэмцээн уралдаануудад цагдаагийн хэлтсийн баг тамирчид тогтмол идэвхи санаачлагатай оролцсон.

Тус хэлтсийн спорт хамтлагаас зохион байгуулах уралдаан тэмцээн, арга хэмжээний хуваарийн дагуу Эрүүгийн цагдаагийн тасгийн нэрэмжит “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулж, алба хаагчдыг шагнаж, урамшуулсан.

Байгууллагын фитнес /бялдаржуулах/ танхимд алба хаагчдыг хичээллэх нөхцөл бололцоог бүрдүүлсэн.

Аймгийн Боржигин чуулгатай хамтран алба хаагчдын ажлын байрны стресс, бухимдлыг арилгах, соёл гоо зүйн мэдрэмжийг дээшлүүлэх чиглэлээр Хөгжим ангийн урлагийн тоглолтыг үзүүлж сонирхуулсан.

Мөн аймгийн нийтийн Номын сан, Боржигин өв музейг үзүүлэх ажлыг зохион

байгуулсан.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эмэгтэй алба хаагчдад эрэгтэй алба хаагчдын зүгээс гарын бэлэг гардуулж, урлагийн номерыг үзүүлж, сонирхуулан тэдний дунд хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгуулж, урамшуулсан.

Захиргааны удирдлагын тасгаас санаачлан Эх орончдын өдрийг тохиолдуулан алба хаагчдын дунд бэлэг солилцох /монита/ арга хэмжээг зохион байгуулсан.

Эрүүгийн цагдаагийн албаны 90 жилийн ойн нэрэмжит дууны тэмцээнд хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч П.Дэлгэрбаяр оролцож, тэргүүн байранд шалгарсан амжилт үзүүлсэн.

Энэ оны эхний улиралд “Сар шинийн баяр”-ыг тохиолдуулан гарын бэлэг гардуулж, хамгийн өндөр настай 3 ахмад настанд сар шинийн тавгийн идээ гардуулж ажилласан.

Албан үүргээ гүйцэтгэж яваад эмь эрсэдсэн алба хаагчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулахаар хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ба “Бид мартаггүй” арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас бэлтгэсэн богино хэмжээний видео бичлэгийг хэлтсийн цахим хаягт байршуулан сурталчилж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан “Ахлагч нарын уулзалт, зөвлөгөөн”-д алба хаагчдыг цахимаар болон танхимаар оролцуулсан.

Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөө, аймгийн засаг даргын хамтран ажиллах гэрээ, аймгийн 2020-2024 оны хөгжлийн хөтөлбөр, зэрэг баримт бичгүүдэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, алба хаагч нарын нийгмийг асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд шинээр болон шилжин томилогдсон алба хаагч нарын гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангахад хамтран ажиллах, амжиргааны түвшин, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөрт хамруулах зэрэг саналыг тусгуулан энэ онд 2 алба хаагчийн гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулав.

Бүтээлч ажил, шинэлэг ажил арга хэмжээний саналыг алба хаагч бүрээс Цагдаагийн хэлтсээс 2024 онд хийж хэрэгжүүлэх бүтээлч ажил, шинэлэг ажил арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулж цагдаагийн хэлтсийн даргаар батлуулан алба хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор бялдаржуулах өрөө, саун, спорт заал, алдрын танхим зэргийг нөөц бололцоогоо ашиглан засвар үйлчилгээ, тохижилтын ажлыг хийж алба хаагч нар хуваарийн дагуу үйлчлүүлж байна.

Хэлтсийн даргын тушаалаар “Хилэнт” хэмээх 17 дугаар жарны төмөр луу жилийн хаврын тэргүүн сарын “Сар шинийн баяр”-г тохиолдуулан 33 ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлж, хамгийн өндөр настай 3 ахмад ажилтанд тавгын идээ, гарын бэлэг гардуулсан.

Алба хаагчдын ар гэрт цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, тэдний ажлын онцлогыг ойлгуулах таниулах ажил, арга хэмжээг зохион байгуулах зорилгоор тус хэлтсийн тасгийн дарга нар хариуцсан алба хаагчдын гэр орноор орж санал хүсэлтийг сонсож ажлын онцлогийг нь таниулах ухуулга яриа хийж хэвшсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/325 дугаартай тушаалаар батлагдсан “Дэд ажлын хэсгийн” мөрдөгчөөр Улаанбаатар хотод томилогдон ажиллаж байгаа 2 алба хаагчийн ар гэрээр орж санал хүсэлтийг сонсож удирдлагад танилцуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас алба, нэгж

хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт өгсөн 5а/9194 дугаартай үүрэг, ажлын чиглэлийг алба бие бүрэлдэхүүнд танилцуулан хэрэгжилтийг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэст сар бүр хүргүүлэн ажиллаж байна.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр шинээр томилогдсон ирсэн 3 алба хаагчийг албаны байранд оруулсан ба 2 алба хаагчийн ар гэрт тус бүр 2 тонн нүүрс олгосон.

“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдаас судалгааг нэгтгэн Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газарт хүргүүлсэн.

“Сүүж-Уул” амралт, сувиллын газарт хүргүүлсэн судалгааны дагуу 4 алба хаагч, гэр бүлийн гишүүдийн хамт амарсан.

Нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлэсэн ажил, арга хэмжээ, төсөв хөрөнгө, зарцуулалт, үр дүнгийн талаар

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөө, аймгийн засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, аймгийн 2020-2024 оны хөгжлийн хөтөлбөр, сумдын засаг дарга нарын мөрийн хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд тодорхой заалтуудыг тусгуулан батлуулж ажиллалаа.

Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид авах арга хэмжээний талаар Цагдаагийн ерөнхий газарт 1, аймгийн Засаг даргад 3, аймгийн салбар зөвлөлд 1, Сүмбэр сумын Засаг даргад 2, нийт 7 танилцуулга бэлтгэн хүргүүлж, 2 саналыг шийдвэрлүүлсэн.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулахаар 28 ажил арга хэмжээний 357.9 сая төгрөгийн саналыг хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Мөрдөн байцаах алба, Урьдчилан сэргийлэх газраас ирүүлсэн “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2024 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэх, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх баримт бичгийн жагсаалт”-ын дагуу нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас биелэлт үр дүнг тооцож, тайлагнах бодлогын баримт бичгийн хяналтад авч, хэрэгжилтийг заасан хугацаанд тайлагнаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/189 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”, “Цагдаагийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх /код 110/ журам”-ыг тус тус баримталж, хэрэгжилтийг нэгтгэж хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх алба, нэгжид жагсаалтад заасан хугацаанд хүргүүлэн ажилласан. Бусад албад, газруудаас хугацаа зааж ирүүлсэн биелэлтийг заасан хугацаанд тайлагнан ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэс болон бусад албадаас санал авахаар ирүүлсэн хууль, журам батлуулах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай 7 төслийг алба хаагчдаар хэлэлцүүлж саналыг хүргүүлсэн.

Аймгийн Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран 2024 оны 1 дүгээр улирлын хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын дарга нарын уулзалт хэлэлцүүлэгт хуваарийн дагуу мэдээлэл бэлтгэж оролцсон.

Аймгийн Прокурорын газартай хамтран зөрчил шалган шийдвэрлэх болон хуулийн хэрэглээнд анхаарах асуудал сэдвээр сургалт зохион байгуулан цагдаагийн хэлтсээс шийдвэрлэх хэргийн графикийг тасаг бүрээр хуваарийн дагуу гаргуулан сар бүрийн 20-ны дотор, Шүүхийн тамгын газартай хамтарч шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажилд тулгамдаж буй асуудал сэдвээр уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж үр дүнг тооцох ажлыг хэвшүүлсэн.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа” журам /код-139/ 139.61в маягтыг алба хаагчдад тусгайлан танилцуулан тэмдэглэл хөтлөн зааварчилга өгөх 1 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 70 алба хаагчдыг хамруулав.

Дотоод хяналт аюулгүй байдлын газраас ирүүлсэн 9 төрлийн зурагт хуудас, гарын авлага хэлбэрээр бэлтгэсэн 60 материалыг хэвлүүлэн Цагдаагийн хэлтсийн хүлээлгийн танхим, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, Аймгийн засаг даргын тамгын газар зэрэг хүн олноор цуглардаг газруудад байршуулан Цагдаагийн хэлтсийн албан ёсны цахим хаягаар иргэд олон нийтэд хүргэх ажлыг тус тус зохион байгуулав.

Авилгын эсрэг “Нэгдье” соён гэгээрүүлэх ажлын хүрээнд байгууллагын авилгаас урьдчилан сэргийлэх самбарт постер зурагт хуудсыг байршуулж Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс фэйж хуудсаар шторк, постер, мэдээллийг тухай бүр байршуулж олон хүн ихтэй аймгийн зарын группуудад түгээлт хийж олон нийтэд хүргэж ажилласан.

Алба хаагчдаас дээрх төрлийн гэмт хэрэгт холбогдсон алба хаагч бүртгэгдээгүй байна.

Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлт, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар

Энэ оны 01 дүгээр улирлын байдлаар иргэдээс нийт 68 өргөдөл ирүүлснээс ажилд орохыг хүссэн 6, ажил өөрчлөх шилжихийг хүссэн 11, ажилд дахин орохыг хүссэн 1, тэтгэвэр тэтгэмж, орон сууц хүссэн 1, захиргааны чөлөө хүссэн 44, бусад 5 хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд журмын дагуу бүртгэл хөтөлж, сар бүр даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох албадад саналыг хүргүүлэн хариуг мэдэгдэж хэвшсэн байна.

Энэ оны байдлаар Засгийн газрын 11-11 төвөөс 1, Цагдаагийн ерөнхий газрын тусгай дугаарын 126 дугаарын утсанд 1, нийт 1 гомдол мэдээлэл бүртгэгдэж албаны шалгалт явуулсанаас гомдол мэдээлэлд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй.

Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар

Энэ онд сахилга, ёс зүйн зөрчилд холбогдож сахилгын арга хэмжээ тооцогдсон 4 алба хаагч байгаа нь урьд оны мөн үеэс 2 нэгжээр буюу 1 дахин өссөн дүнтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 01 “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгавар, 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд, дэд дарга нараас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг тусгайлан бүртгэж,

алба хаагчдад танилцуулж, сургалтыг зохион байгуулах төлөвлөгөө, хариуцах алба хаагчийг томилж сар бүр даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж үр дүнг тооцон ажиллав.

Цагдаагийн хэлтсийн сахилга хариуцлагын зөвөлгөөнийг 1 удаа зохион байгуулан Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээний явц, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд, Дэд даргын өгсөн үүргийн биелэлт үр дүнгийн талаар танилцуулж, цагдаагийн хэлтсийн даргаас сахилга ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр алба хаагч нарт 4 төрлийн хугацаатай үүрэг, зааварчилгааг өгч, үр дүнг сар тооцон ажилласан.

Дотоодын хяналтыг сайжруулах чиглэлээр өдөр бүр нэгдсэн рапортны дараа мөрдөгч нарын гар дээр шалгаж байгаа хэрэг материалыг тулгаж, өдөрт хийх ажлыг төлөвлөж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг бүрт, шалгах, түүвэр төлөвлөгөөг хийлгэж, ажлын өдөр тогтмол 18:00 цагт гомдол, мэдээлэл, хэрэг материалыг шалгах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажилтай биечлэн танилцаж, үүрэг чиглэл өгч, 14 хоногт хийсэн ажлаа нэгтгэн танилцуулах, аймгийн Прокурорын газарт хэргийг ажиллагааны хугацаанд нь хянуулах зэрэг ажлыг зохион байгуулж хэвшүүлсэн.

Тасгийн дарга болон ахлах мөрдөгч нар мөрдөн байцаалтын хэрэг материал бүрийг уншиж мөрдөгч нарт ажлын чиглэл, зааварчилгаа тухай бүр өгч, мэдээллийн санд гомдол мэдээлэл, гэмт хэргийн шийдвэрлэлт хөдөлгөөнийг хянан баталгаажуулах, алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах талаар үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцон ажиллав.

Цагдаагийн хэлтсийн давхардсан тоогоор 72 алба хаагчдаас ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх, сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх, нууцлал аюулгүй байдлыг хангах, цахим орчин дахь мэдээлэл, нууцлал, аюулгүй байдлын талаар баталгааны хуудсаар 1 удаа баталгаа авч, тасаг хэсгийн дарга нар хяналт тавьж ажилласан.

Байгууллагын дотоод хөдөлмөрийн зохион байгуулалтыг зөв оновчтой болгох, алба хаагч, ажилтаны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх талаар үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулах талаар алба хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулахад өглөөний рапортыг багасгаж ажлын бүтээмжийг сайруулах дийлэнх олонхын саналын дагуу өглөөний рапортыг Мягмар, Пүрэв гаргагуудад явуулахаар багасгасан нь ажлын цагийн бүтээмжийг 4 цагаар нэмэгдүүлсэн зохион байгуулалтын арга хэмжээ болсон.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын ажилдаа хандах хандлага, харилцаа, сэтгэлгээг хөгжүүлэх ажлын төлөвлөгөө”, мөн даргын А/142 дугаартай тушаалаар баталсан “Алба хаагч-таны төлөө” нөлөөллийн аяны салбар төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажилласан.

Санхүүгийн үйл ажиллагааны талаар

Цагдаагийн хэлтэс нь 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар батлагдсан төсвийн санхүүжилт 718,722,600.00 /долоон зуун арван найман сая долоон зуун хорин хоёр мянга зургаан зуун/ төгрөг, гүйцэтгэл нь 684,484,307.46 /зургаан зуун наян дөрвөн сая дөрвөн зуун наян дөрвөн мянга гурван зуун долоон төгрөг дөчин зургаан/ мөнгө буюу 95.2 хувь. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 1,374,900.00 /нэг сая гурван зуун далан дөрвөн мянга есэн зуун/ төгрөг, гүйцэтгэл нь 4,070,975.00 /дөрвөн сая далан мянга есэн зуун далан таван/ төгрөг буюу 296 хувьтай биелсэн.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан.Үүнд: цалинд 570,255,592.23 /таван зуун далан сая хоёр зуун тавин таван мянга таван зуун ерэн хоёр төгрөг хорин гурван/ мөнгө, нийгмийн даатгалын шимтгэлд 13,270,315.23 /арван гурван сая хоёр зуун далан мянга гурван зуун арван таван төгрөг хорин гурван/ мөнгө, Байр ашиглахтай холбоотой тогтмол зардалд 72,454,100.00 /далан хоёр сая дөрвөн зуун тавин

дөрвөн мянга нэг зуун/ төгрөг, Тээвэр шатахууны зардалд 12,001,900.00 /арван хоёр сая нэг мянга есөн зуун/ төгрөгийг зарцуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлыг Сангийн сайдын 2021 оны 06 сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралт “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмыг баримтлан цагдаагийн хэлтсийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар цагдаагийн хэлтсийн шатахуун, шатах тослох материал нийлүүлэх нийлүүлэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж шатахуун, шатах тослох материал нийлүүлэх ГСАЦХ/202401001 нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 33 дугаар зүйлийн дагуу tender.gov.mn сайтад цахимаар зарласан.

Цагдаагийн хэлтсийн шатахуун, шатах тослох материалын жилийн төсөв 72,994,600.00 /далан хоёр сая есөн зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун/ төгрөг батлагдсан ба шатахуун, шатах тослох материал нийлүүлэх нээлттэй тендерийн хурлыг энэ оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулж, үнэлгээний хорооны гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, тендэрт “НИК” ХХК шалгарч 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд шатахуун, шатах тослох материал нийлүүлэхээр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Shilendans.gov.mn сайтад 2023 онд нийт 171 мэдээлэл байршуулахаас 42 мэдээллийг хугацаанд бүрэн байршуулсан.

Аж ахуйн чиглэлээр

Замын цагдаагийн постонд тавигдсан цахилгаан халаагуурын ажиллагаанд хяналтыг 7 хоног тутамд шалгаж, өвлийн улиралд халаалтыг хэвийн ажиллуулсан.

Цагдаагийн хэлтсийн хуваарилагдсан талбайд цэвэрлэгээ үйлчилгээг энгийн 2 ажилтан болон баривчилагдсан иргэдээр цэвэрүүлж, цагдаагийн хэлтсийн хогийг 11 удаа Тохжилт сүмбэр ОНӨҮГ-т дуудлага өгч ачуулж ажилласан.

Албаны тээврийн хэрэгслийн засварын ажилд хяналт хийж, шаардлагатай сэлбэг хэрэгслийг “Өмч хамгаалах байнгын комисс”-оор хуралаар гарсан шийвэрийг үндэслэн Тоёото приус 20 маркийн 01-02ГСА улсын дугаартай тээврийн хэрэгсэлд акумлятор, амортизатор, дарны сэнс, таван бул, өндгөн тулгуур, Пробокс маркийн 00-76ГСА улсын дугаартай тээврийн хэрэгсэлд перда диск, фургон маркийн 26-86ГСА улсын дугаартай тээврийн хэрэгсэлд хойд хөтлөгч, хацар зөрөх араа зэрэг сэлбэг хэрэгслийг худалдан авч албаны бэлэн байдлыг хангасан.

Албан хаагчдын биеийн хэмжээг 2024 оны байдлаар шинэчлэн судалгааг гарган хангалт үйлчилгээний төвд албан бичгээр хүргүүлсэн.

Конторын барилгын хойд талд гадна лед гэрэлтэй товгор POLICE хаягийн тооцоо гарган Анутүшиг ХХК-тай гэрээ хийж захиалга өгч хийгэн хүргэлтээр авч аюулгүй байдлаа бүрэн хангаж 3 давхарт гадна хаяг тогтоосон.

Цагдаагийн хэлтсийн POLICE гэрэлтүүлэг POL үсэг салхинд хийсэж хагарсан засварлах боломжгүй болсон тул шинээр үсэг захиалж POLICE бичиглэлийг бүрэн болгосон.

Хүүхдийн болон эмэгтэйчүүдийн өрөө шинээр байгуулахтай холбоотой хүүхдийн өрөөнд таац нурсан гибсэн хавтанг гураан шинээр гибсэн хавтан зүсэж тааруулан цагаан замаск татан хатсан хойн зүлгүүр хийж эмульс түрхсэн. Цонхны сийгэлтийн арилгахийн тулд силкон түрхсэн, хөшиг тогтоогчийг тогтоосон, эмэгтэйчүүдийн өрөөнд паарны ар талд цагаан замаск тогтоон эмульс түрхсэн.

Өвөлжинт хүндрэлтэй үед малчдад туслах аянд нэгдэн Малхийн талруу 150 боодол өвс, 5 шуудай хивэг, 1 тонн нүүрс, улаан загалмай нийгэмлэгийн малчин багцыг малчин

өрхөд хүргэх ажлыг зохион байгуулж 8 алба хаагчийн хамт 1 ачааны машин, 1 суудлын тээврийн хэрэгслээр 2 өдөр буюу 48 цаг тасралтгүй гараар цас ухаж зам гарган малчин өрхөд сэтгэлийн болон материалын тусламж хүргэсэн.

Хүйтэн цэвэр усны тоолуур, шүүгч халаагч, хаалтыг УСДУ хамтран шинээр суурилуулах, спорт заалны халаалтын паарны хөлдөлтийг арилгасан.

Албан ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн д/ч Б.Сумьяабазар, д/ч Шинэбаяр нарын хувцсаны тооцоо болох 1,631,869 төгрөгний тооцоог хангалт үйлчилгээний төвд бүрэн барагдуулж тооцоогүй гэсэн хуудас авсан.

Цагдаагийн хэлтсийн аюулгүй байдлын хангах үүднээс зэвсгийн өрөөний цонхонд эршотик, тень нааж аюулгүй байдлыг хангасан. “Илчит сансар ХХК”, БЗӨБЦТС-н ажилчидтай Цагдаагийн хэлтсийн байранд үзлэг шалгалтыг 1 удаа зохион байгуулсан. Тус хэлтсийн зочид төлөөлөгч хүлээн авдаг гэрийн хаалга эвдэрсэн засварлах боломжгүй болсон тул шинэ хаалга 250,000 төгрөгөөр хийлгэж суурилуулсан.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр

Энэ оны 01 дүгээр улирлын байдлаар аймаг, орон нутаг болон Цагдаагийн ерөнхий газраас ирсэн үндсэн хөрөнгө, бараа материал байхгүй.

Сэтгэл зүйчийн ажил арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар

Сэтгэл зүйчийн зүгээс ганцаарчлан уулзах хүсэлтэй 33 алба хаагчтай уулзаж, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэхэд нь сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан. 24 цагаар үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг тухайн өдөр нь “Хуянгийн болон хөлний” массажны аппаратад оруулж ажилласан.

Бүлгийн сэтгэл засалын төлөвлөгөө гаргаж 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг 5 алба хаагчдын дунд 1 удаа зохион явуулсан.

Ажлаас халшрах хам шинж, нойргүйдэл, стресстэй, сэтгэл түгшилт, сэтгэл гутрал өндөр илрэлтэй 8 алба хаагчдад давхардсан тоогоор 5 удаа ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө болон, 3 удаа бүлгийн сэтгэл засалд хамруулан ажилласан.

Алба хаагчдаас авсан сэтгэл зүйн судалгааны үр дүнд үндэслэн Цагдаагийн албаны тухай хуулийн 86.11 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн алба хаагчийг сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулах журам”-ын хэрэгжилтийн хүрээнд Сүүж-Уул амралтын газарт 2024 оны 01 сараас нийт 4 алба хаагч, гэр бүл 2, хүүхэд 2 нийт 8 хүнийг сувилуулж ажилласан.

Шинээр ажилд орох хүсэлт өгсөн 2 иргэн, цагдаа дамжаанд явах олон нийтийн цагдаагаар ажиллаж байгаа 2 алба хаагч, нартай ярилцлага хийж, шалгалтын материалыг хүний нөөцийн ахлах мэргэжилтэн Д.Нэргүйд хүргүүлж ажилласан.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд албан тушаал дэвших сул орон тооны сонгон шалгаруулалтад оролцох ярилцлага хийн, сэтгэл зүйн сорил авч мэргэжилд тохиоц байдлын дүгнэлт гаргах ажлыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журам болон Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны А/403 дугаартай тушаалд заасны дагуу шүүхийн харуулын цагдаа, ахлах ахлагч Б.Баярцэнгэл, хэсгийн цагдаа, ахлагч Ш.Баянзул, цагдаа зохицуулагч, дэд ахлагч Б.Баттүвшин болон цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-Аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд сэтгэл зүйн тасгийн сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч Б.Төрболд мөн оны 03 дугаар сарын 27-ны өдөр утсаар /99561004/ өгсөн үүргийн дагуу Дундговь аймгийн цагдаагийн газрын цагдаа жолооч, цагдаагийн ахлах ахлагч Ц.Мөнгөнсүх, НХЖХОНАБХ Тасгийн эргүүлийн цагдаа,

цагдаагийн дэд ахлагч Г.Далх нар нийт 5 алба хаагчид мэргэжил тохироц байдлыг хийж, үнэлэлт, тодорхойлолтыг гаргаж холбогдох мэргэжилтэнгүүдэд тус тус хүргүүлж ажилласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтсээс 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 38ж/289 тоот албан бичгийн хүрээнд тус сумын “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын ахлагч нарын чуулга уулзалт”-д “Сэтгэл зүйн боловсрол, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах нь” сэдвээр 1 цаг 30 минутын сургалтыг 180 алба хаагчдад зохион явуулсан.

Бусад ажлын талаар

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар Цагдаагийн ерөнхий газар болон бусад албад, төрийн болон төрийн бус байгууллагаас нийт 1448 албан бичиг ирүүлснээс хариутай 883 албан бичиг хүлээн авч, 663 бичгийн хариуг заасан хугацаанд нь хүргүүлсэн. Одоо хяналтад байгаа 117 албан бичиг байна.

Цагдаагийн ерөнхий газар болон бусад байгууллагууд руу 1222 албан бичиг хүргүүлж, тусгай шуудан 14 удаа хүлээн авч, 15 удаа явуулж ажиллав.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга, дэд дарга нараас ирүүлсэн 12 үүрэг ажлын чиглэлийг бүртгэн холбогдох албан тушаалтанд шилжүүлж ажилласан.

Алба хаагчдын сахилгын хураангуй, дэлгэрэнгүй, албаны шалгалт, алба хаагчтай холбоотой өргөдөл, гомдол, алба хаагч өртөж, хохирсон талаарх, иргэдээс байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, албаны сургалт, соён гэгээрүүлэх ажлын болон хүний нөөцийн хөдөлгөөний тайлан мэдээг тус тус хугацаанд нь холбогдох албадад хүргүүлж ажилласан.

Хэлтсийн даргаас тасаг, хэсгийн дарга нарт, тасаг, хэсгийн дарга нараас алба хаагчдад өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтүүдийг тухай бүр тооцож хэвшүүлсэн. Цагдаагийн хэлтсийн даргаас өгөгдсөн нийт 4 удаагийн үүрэг, чиглэлийн биелэлтийг гаргаж, үр дүнг тооцсон байна.

Цагдаагийн хэлтсийн 2023 онд үүссэн архивыг тасаг хэсгээс хүлээн авч, 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Цагдаагийн хэлтсийн баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар батлуулж Цагдаагийн ерөнхий газрын төв архивт хүргүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн баримт нягтлан шалгах комиссын ээлжит хурлыг 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хуралдаж Тус хэлтэст хадгалагдаж байгаа 2007-2010 оны зөрчлийн материалуудыг шууд устгах, 2012-2018 оны материалуудыг журмын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн холбогдох материалуудыг устгах саналыг хэлэлцэн хуралдааны тэмдэглэлийг Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын дэргэдэх баримт нягтлан шалгах комисст хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Устгах 4679 ширхэг хадгаламжийн нэгжийг Төрийн архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын 1 дүгээр хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг угтаж үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд хийгдэх үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсөв, тооцоо, санхүүжилтийг батлуулан байгууллагын архивын өрөөны хаалгыг төмөр хаалгаар солиулан, баримт хадгалатын аюулгүй байдал буюу хамгаалалтын шаардлагыг хангаж, хамгаалалтын болон галын дохиоллын систем, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, галын самбарыг хадгаламжийн санд суурилуулах ажлыг зохион байгуулан ажилласан.

ЦЕГ-ын Төв архивын БНШК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн хурлаар тус цагдаагийн хэлтсийн архивт хадгалагдаж байгаа 2009, 2012-2018 оны зөрчлийн хэрэг,

материалын архивын нэгжийг устгахаар шийдвэрлүүлсэн.

Алба хаагчдын ажиллах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор хүүхдийн болон эмэгтэйчүүдийн өрөөг бий болгох санал гарган хэлтсийн В1 давхарт эмэгтэйчүүдийн хэлтсийн спорт зааланд хүүхдийн өрөөг засч тохижуулан ашиглалтад оруулсан.

ХОЁР: ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр

Энэ онд нийт 56 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 19-өөр буюу 51.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хүнд гэмт хэрэг 7 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 1-ээр буюу 16,7 хувиар, хөнгөн гэмт хэрэг 49 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 18-аар буюу 58,1 хувиар өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 55,8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,9 хувиар өссөн байна.

Эрэн сурвалжлах ASAP санд 3 оргодлыг эрэн сурвалжилж олж тогтоосон ба эрэн сурвалжилж байгаа оргодол байхгүй. Урьд онд гэмт хэрэгт сэрдэгдсэн 3, энэ онд 6, нийт 9 этгээдийг эрэн сурвалжилж, үүнээс 6 этгээд буюу 66,6 хувийг олж тогтоосон.

Одоо гэмт хэрэгт сэрдэгдсэн 3 этгээдийг эрэн сурвалжилж байна. Шүүхээс даалгасан хүнээр энэ онд 17 иргэнийг зарлаж, 10 иргэн ийг олж тогтоосон.

Оршин суугаа газраасаа сураггүй алга болсон урьд онд 1, энэ онд 9, нийт 10 хүнийг эрэн сурвалжилж, 9 хүнийг олж тогтоосон. Одоо 1 иргэнийг эрэн сурвалжилж байна.

Зөрчил үйлдсэн этгээд энэ онд 4 зарлаж 3 этгээдийг олж тогтоон одоо 1 этгээдийг эрэн сурвалжилж байна. Эрэн сурвалжлалтын хувь 75%-тай байна.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах "ASAP" санд эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал амьтан, эд зүйлийн мэдээллийг оруулахдаа хэргийн ангиллыг үнэн зөв, бүрэн гүйцэд оруулж, эрэн сурвалжлагдаад олдоогүй байгаа хүн, эд зүйлийн талаар зохиомлоор эрэн сурвалжлалтыг хааж, дүн мэдээнд зөрүүтэй байдал гаргахгүй байх талаар алба хаагчдыг үүрэгжүүлэн ажилласан. Нийт бие бүрэлдэхүүний эрэн сурвалжлах "ASAP" санд хандаж байгаа хандалтын тоог сарын ажил дүгнэх хурлаар хэлэлцүүлж, шалгуур үзүүлэлт болгон хэвшүүлсэн.

Мөрдөн байцаалтын чиглэлээр

Энэ оны 1 дүгээр улиралд иргэд, аж ахуй нэгжээс 64 гомдол мэдээлэл хүлээн авч, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 20, Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 11, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 20, одоо ажиллагаанд 13 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Хэрэг бүртгэлтийн өмнөх оны 11, энэ оны 32 нийт 43 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хаах саналтай 16, Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 15, одоо ажиллагаанд 12 хэргийн үлдэгдэлтэй байна.

Мөрдөн байцаалтын өмнөх оны 6, энэ оны 37 нийт 43 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхэд шилжүүлэх саналтай 34, хэрэгсэхгүй болгох саналтай 1, харьяаллын дагуу шилжүүлсэн 1, одоо ажиллагаанд 7 хэргийн үлдэгдэлтэй байна.

Мөрдөн байцах албаны хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсээс зохион байгуулж буй урьд оны дугаартай Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр бүлгийн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэтийг ахиулах чиглэлээр зохион байгуулж буй "Шийдвэрлэлт" хэсэгчилсэн арга хэмжээг энэ сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулах төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна.

Замыг цагдаагийн албаны чиглэлээр

Цагдаагийн хэлтсийн жижүүрийн шуурхай албаны тусгай дугаарын 102 утсанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн зам тээврийн ослын 21 гомдол, мэдээллийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны / код 202 /-ын дагуу хүлээн авснаас, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 15, зам тээврийн осол 6 бүртгэгдэж, осол хэргийн улмаас нас барсан 3, гэмтсэн 9 хүн байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор босоо тэнхлэгийн А0101 дугаартай автозамд байрлах байнгын хяналтын постод 24 цагаар, өдөр болон оройн эргүүлд 2 автомашинтайгаар гудамж замын хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа. Гудамж замын хяналт шалгалтаар 6250 зөрчил илрүүлснээс бэлэн бусаар 6162 зөрчил 180.065.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, цагдаагийн байгууллагын АСАП санд эрэн сурвалжлагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эд зүйлс, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, тээврийн хэрэгсэл 11 олж тогтоон, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 56 зөрчил, эрхийн үнэмлэхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 21 зөрчлийг тус тус илрүүлэн Монгол Улсын Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцон ажилласан.

Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ын 1 дүгээр хавсралтын 1.2 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж Зам тээврийн ослын үед шийтгэлийн хуудас 1, 2 бичиж байгаа тохиолдолд цагдаагийн байгууллагын зөрчлийн санд шивж оруулахдаа зам тээврийн осол үйлдсэн этгээд эсэхийг тийм /5 оноо хасах/ төлөвийг сонгож ямар нэгэн алдаа дутагдалгүй ажиллаж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дахь заалтын дагуу тогтоосон хугацаанд торгуулийг нөхөн төлөөгүй иргэдийн материалыг шүүн гаргаж энэ оны 03 дугаар сарын 22-ны өдөр Говьсүмбэр аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 3 ширхэг материалыг эрх бүхий албан тушаалтны хүсэлтийг хүргүүлж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар албадан гүйцэтгэхээр шийдвэрлүүлсэн. Мөн тээврийн хэрэгслүүдийн торгуулийг шүүж үзэж бэлэн бус торгуулийг төлөх хугацаандаа төлөөгүй 76 жолоочийн 7.328.000 төгрөгийг торгуулийг нөхөн төлүүлж ажилласан байна.

Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албанаас төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдах нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, “Мотоцикл”, “Уусан бол бүү жолоод” “Илрүүлэлт-Шийдвэрлэлт-Оргодол” зэрэг арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө гарган зохион байгуулан биелэлт үр дүнг тооцон хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ын 1 дүгээр хавсралтын 1.2 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж Зам тээврийн ослын үед шийтгэлийн хуудас 1, 2 бичиж байгаа тохиолдолд цагдаагийн байгууллагын зөрчлийн санд шивж оруулахдаа зам тээврийн осол үйлдсэн этгээд эсэхийг тийм /5 оноо хасах/ төлөвийг сонгож ямар нэгэн алдаа дутагдалгүй ажиллаж байна.

Нийтийн хэв журам хамгаалах ажлын чиглэлээр

Нийтийн хэв журам хамгаалах тасгаас хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгээс цагдаагийн байгууллагад холбогдох заалтуудын биелэлт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний холбогдох заалтуудын биелэлт болон

дээд шатны байгууллагаас ирүүлсэн 115 удаагийн үүрэг даалгавар, ажлын чиглэл, албан бичгийн хугацаанд нь гаргаж, Цагдаагийн ерөнхий газар, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, болон холбогдох газруудад тус тус хүргүүлсэн.

Энэ оны 01 дүгээр улирлын байдлаар алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгтгэлийг гаргаж алба хаагчдад 20-40 хүртэлх хувийн цалингийн урамшууллыг олгох ажил арга хэмжээг зохион байгуулсан.

Тус тасгаас алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Эрүүлжүүлэх саатуулах байрны 2 эмчийг 7 хоногт 2 удаа, авто эргүүлийн 4 алба хаагчийг орой, 2 алба хаагчийг өдрийн явган эргүүлд ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан.

Дээрх зохион байгуулалтыг хийснээр 2023 оны 3 дугаар сард зөрчил үйлдсэн 110 хүнийг 1.630.000 төгрөгөөр торгож байсан бол 2024 оны 3 дугаар сард 172 хүнд 1.855.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 62 буюу 56.3 хувиар өсөж нэгжийн ажлын үзүүлэлт эерэг дүнтэй гарсан.

Мөн 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг ээлжээс буух өдөр албаны сургалт, соён гэгээрүүлэх, бусад ажил арга хэмжээнд татан оролцуулах байх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

Ажлын байрны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэсгийн байцаагч нарын өрөө тасалгаанд шаардлагатай 11 эд материалын 3,696,000 төгрөгийн тооцоо судалгааг гаргаж шийдвэрлүүлэхээр Сүмбэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 36д/208 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Дээрх ажил арга хэмжээний хүрээнд Сүмбэр сумын хэсгийн байцаагчийн өрөөнд энэ оны 03 дугаар сард Цонхны хөшиг 1 ширхэг, төмөр хаалт 1 ширхэг, свич-1 ширхэг, вэб камер-1 ширхэг ус шүүгч 1 ширхгийг тус тус шийдвэрлүүлж ажиллах нөхцөл орчинг сайжруулах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Мөн баянтал сумын цагдаагийн 1 алба хаагчийн амьдарч буй албаны байрны орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 600,000 төгрөгийн урсгал засварыг энэ оны 03 дугаар сард хийж гүйцэтгэсэн. Эрүүлжүүлэх саатуулах байрны эмч цагдаа нарын өрөөг байнгын халуун, хүйтэн цэвэр устай байлгах үүднээс цэвэр усны төхөөрөмжийг төвийн шугамд холбуулах ажил арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Тус тасагт данстай албан үүрэг гүйцэтгэж буй 0017 ГСА дугаар бүхий албаны авто машины хуучирч муудсан Police бичиглэл, жолооч талын эсрэг хойд хаалга, шил арчигчийг сольж ажиллах нөхцөлийг сайжруулсан. Мөн гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Криминологи дүн шинжилгээ, судалгаанд суурилан согтуугаар үйлдэгддэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг бууруулах, арилгах чиглэлээр Сүмбэр сумын засаг даргын тамгын газар болон иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран “Итгэл төслийг боловсруулж ахуйн хүрээнд болон гудамж талбайд архи дан согтуурч гэмт хэрэг зөрчилд өртөж, холбогдож болзошгүй согтууруулах ундааны хамааралтай 17 иргэнийг Сайн дурын эмчилгээнд хамруулахаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтүүлэн хордлого тайлуулах, бусад зан үйлд нөлөөлөх сургалт, эмчилгээг хийлгэн ажиллаж байна.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүлжүүлэх саатуулах баривчлах байранд хүргэгдэн ирсэн 6 иргэний гарын дардсыг шинжээч эмчээр авхуулж асап сангийн баяжилтыг хийж ажилласан. Цагдаагийн хэлтсийн сургалт соён гэгээрүүлэх хөтөлбөрийн хүрээнд Аймгийн насан туршийн боловсролын төвтэй хамтран “Монгол бичиг”-ийн анхан шатны 20 цагийн багц сургалтад тасгийн 21 алба хаагчийг хамруулсан.

Аймгийн боржигин чуулга, спорт хороо, Политехник коллеж зэрэг 3 аж ахуй нэгж байгууллагуудын байранд энэ оны 03 дугаар сард зохион байгуулагдсан Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах "Заалны Крикет" тэмцээн, Төрийн албаны шалгалт, Монголын Волейболын холбооны идэрчүүдийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн, Хөгжөөн дэмжигчдийн бүсийн тэмцээн зэрэг нийтийг хамарсан олон нийтийн арга хэмжээ, үйл ажиллагаанд 5 удаа 15 алба хаагчийн хамтаар хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

Мөн Алба хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, тасгийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор энэ оны 03 дугаар сард “Танин мэдэхүйн 35 асуулт”, “Албаны бэлтгэлжилт” зэрэг 2 удаагийн сургалтыг тасгийн 21 алба хаагчдад орсон.

Алба хаагч, ажилтны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, Эрүүл монгол хөтөлбөрийн хүрээнд тасгийн 21 алба хаагчаас 14 алба хаагч буюу нийт алба хаагчийн 90 хувийг “Энхт-Тус Дэм” өрхийн эмнэлэгтэй хамтран урьдчилан сэргийлэх шээс, цусны шинжилгээнд хамруулж өдрийн эмчилгээг хийлгэсэн.

Мөн аймгийн нэгдсэн эмнэлэгт 1 алба хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 10 хоног хэвтэн эмчлүүлэх нөхцөл боломжоор хангасан.

Мөн аймгийн прокурорын газартай 2024 оны 03 дугаар сарын 13-ний өдөр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, Эрүүлжүүлэх саатуулах баривчлах байрны өнөөгийн нөхцөл байдал цаашид анхаарах асуудлын талаар хамтарсан 1 удаагийн зөвлөгөөнийг зохион байгуулж ажилласан.

Явган болон хөдөлгөөнт эргүүлд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын албан үүргээ гүйцэтгэх хугацаанд нь иргэдээс ирүүлсэн дуудлага, мэдээлэл нэг бүрийг энгэрийн камерт бичлэг хийж байгаа байдалд тасгийн дарга, ахлах байцаагч нар хяналт тавьж ажилласан.

Эрүүлжүүлэх саатуулах байранд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 59 /үүнээс гэмт хэрэгт холбогдсон 24/, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан 96, нийт 155 хүнийг хүлээн авч ажилласан.

Цагдаагийн хэлтсээс Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар баталсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр” журмын дагуу тус байранд баривчлах шийтгэлтэй ирсэн иргэдийн зан үйлд нөлөөлөх сургалтын танхимыг тохижуулан үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт 64 иргэнд давхардсан тоогоор 849 цагийн албадан сургалтыг явуулж ажилласан.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ахлах байцаагч 1, харуулын цагдаа 3, хамгаалалтын цагдаа 1 гэсэн орон тоотойгоор үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа ба харуулын болон хамгаалалтын цагдаа нар 24 цагаар 91 удаа 2184 цаг хамгаалалтын үүрэг гүйцэтгэх, шүүх хурлын дэг сахиулах, хэв журам сахиулах явган эргүүлд тус тус үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Говьсүмбэр аймаг дахь шүүхээс 2024 оны 1 дүгээр улиралд зарлагдсан эрүүгийн хэргийн 75 , зөрчлийн хэргийн 83, иргэний хэргийн 59 , захиргааны хэргийн 2, давж заалдах шатны 10 Захиргааны хэргийн 2 нийт 231 шүүх хуралд журам сахиулж ажилласан. Шүүгч 291 , улсын яллагч 154, нарийн бичгийн дарга 231 , холбогдогч 81 , хариуцагч 63, нэхэмжлэгч 59 , өмгөөлөгч 110, шүүгдэгч 75, гэрч 30, хохирогч 40, яллагдагч 8, бусад 75 нийт 1211 , оролцогчийг шүүх хуралд оролцоход нь аюулгүй байдлыг хангасан.

Шүүхийн байрны гадна болон дотор аюулгүй байдалд хяналт тавьж Шүүхийн байранд хандаж ирсэн 1050 иргэнийг зохих журмын дагуу шүүхийн байранд нэвтрүүлсэн. Шүүгчийн нүүдлэн ажиллах үеийн хамгаалалтад нийт 7 удаа ажилсан. Цагдан хорих байрнаас-Шүүхэд 11, Шүүхээс-Цагдан хорих байранд 18 нийт-29 удаа хучглан тээвэрлэсэн. Мөн өглөө бүр шүүхийн байрны камерын бичлэгийг шүүхийн тамгын газраас болон ахлах байцаагч, тасгийн дарга нараас шалгаж харуулын цагдаа нарт үүрэг чиглэл өгч, өдөр тутам хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан. Шүүхийн байранд нэвтэрсэн 1050 иргэнийг бэлэн бус торгуулийн машин ашиглан хувийн байдал болон эрэн сурвалжлагдаж байгаа эсэхийг тогтоон нэвтэрсэн иргэдийн бүртгэлд бүртгэн ажиллахад ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй.

Эрэн сурвалжлах, албадан ирүүлэх цахим бүртгэлээр энэ онд 13 иргэний талаар мэдээлэл ирснийг хүлээн авч, холбогдох албан тушаалтнуудад шилжүүлэн цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд бүртгэн нийт 13 иргэнийг эрэн сурвалжилснаас 11 иргэнийг олж тогтоосон.

Шүүхийн байраар үйлчлүүлж буй иргэдийг гараар бүртгэгдэг байдлыг өөрчилж техник технологи /QR КОД/ ашиглан цахимаар бүртгэх ажил арга хэмжээг шинээр нэвтрүүлсэн.

Энэ ажил арга хэмжээг НХЖХОНАБХА-ны Шүүгч, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсээс улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 44 шүүхийн байранд нэвтрүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгаас, Шүүхийн тамгын газартай хамтарсан зөвлөгөөнийг энэ уриралд 1 удаа зохион байгуулж шүүхийн аюулгүй байдлыг хангах, өдөр тутмын үйл ажиллагаанд гарч буй зөрчил дутагдал, алдаатай асуудлыг хэлэлцэж, цаашид хийж хэрэгжүүлэх ажил, анхаарах асуудлын талаар санал солилцон зөвлөгөөнөөс гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шуурхай удирдлагын албаны чиглэлээр:

Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс нь иргэн, хуулийн этгээдээс 325 гомдол иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 92 дуудлага, мэдээллийг өнгөөр нь авч үзвэл: хүний амьд явах эрхийн эсрэг-11, өмчлөх эрхийн эсрэг-12, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг-20, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг-4, залилах-20, хөрөнгө завших-1, худал мэдээлэл тараах-2, Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах-5, хүрээлэн байгаа орчны эсрэг-1, зам тээврийн ослын-10, эрхээ хасуулсан этгээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон-4, бусад-2 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Зөрчлийн шинжтэй 223 дуудлага, мэдээллийг өнгөөр нь авч үзвэл бусдын биед халдах-8, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн-30, хулгайлах-1, олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах танхайрах-43, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын зөрчил 101, хүүхдийн эрх зөрчсөн 8, хууль сахиулагчийг эсэргүүцэх-2, тамхины хяналтын тухай хууль зөрчих-2, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих-6, бусад 22 зөрчил бүртгэгдсэн байна. Цагдаагийн хэлтсийн 102 тусгай дугаарын утсанд иргэн, байгууллагаас ирүүлсэн 318 дуудлага, мэдээллээс 2024 оны 01 дүгээр улирлын байдлаар /100 хувь/ иргэдтэй холбогдон тэдний санал хүсэлтийг сонсож тэмдэглэл үйлдэж цагдаагийн хэлтсийн дарга, удирдлагуудад танилцуулан дуудлага мэдээллийг бүрэн шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавьж иргэдэд хариу өгөх ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийг мэдээллээр хангах зорилгоор Шуурхай удирдлагын тасгийн самбарыг хүлээлгийн танхимд байршуулж эрэн сурвалжлалт, зарлан мэдээлэл, урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах болон шаардлагатай бусад мэдээллийг долоо хоног бүр шинэчлэн ажилласан.

Аймгийн хүү торгуулийн орлогын дансанд 2023 онд 790.210.500 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн ба орон нутгаас 38.959.000 төгрөгөөр Цагдаагийн хэлтэст байрлах теле хяналтын төвийн дэд бүтэц сайжруулах зорилгоор 65 инч 4 ширхэг дэлгэц, 8 тера байтын 6 ширхэг хард, 128 камерын багтаамжтай “Dahua” брэндийн бичигч төхөөрөмжийг шийдвэрлэж өгсөн.

Сүмбэр сумын 1 дүгээр багийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг цэгийн судалгааг гаргаж Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд танилцуулж 2023 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн 119, 120 тогтоолоор 38.500.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Сүмбэр сумын 1, 2 дугаар багт 2017 онд суурилуулсан теле камераас тайлант хугацаанд ажиллагаагүй болсон 17 цэгийн 30 теле хяналтын камерыг засварлуулж, Сүмбэр сумын 1 дүгээр багийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг цэгт шинээр 15 чиглэлийн камер суурилуулах 38.500.000 төгрөгийг энэ оны 10 дугаар сарын 16-ны өдөр шийдвэрлэсэн бөгөөд 2024 оны 1-р улирлын байдлаар 5 цэгийн 7 камер засварлаж, 3 цэгийн 7 камер шинээр суурилуулан теле хяналтын төвд бүрэн холболт хийгдсэн бөгөөд теле хяналтын камерын засварын ажил хийгдэж байна.

Шивээговь сумын ИТХ-ийн даргын 2024 оны 03 сарын 28-ны өдрийн № ШХА-01 дугаар шийдвэрээр “Сумын төвийн гудамж талбайн камерыг засварлах, шинээр камер нэмэгдүүлэх” шууд худалдан авалтын 19 сая төгрөгийг шийдвэрлэсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс нь иргэн, хуулийн этгээдээс 325 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 100 буюу 30.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 225 буюу 69.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Бүртгэгдсэн гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүлээн авсан нийт гомдол мэдээлэл 43-аар буюу 15.2 хувиар өссөн.

Нийт 6365 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 310 буюу 5.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт 6279 иргэнийг 224720.0 төгрөгөөр торгож 34 иргэнийг баривчлуулж, 51 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасчээ.

Энэ онд криминологи судалгааны багийн хурлыг 14 хоног тутам хуралдуулж, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” Монгол улсын хууль, цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ, үйлдэгдэж байгаа хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг тайлбарлан таниулах, цаашид хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мэдээлэх талаар зөвлөж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргаас 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр “Аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн хэлтсээс мэдээлэл хийх алба хаагчдын хуваарь”-ийг батлан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд албан бичгээр хүргүүлээд байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллахаар цагдаагийн 71 алба хаагч 143 байгууллагад хуваарьлагдан ажиллаж, алба хаагчдаас хариуцуулсан байгууллагуудад мэдээлэл хүргэж, цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулж байгаа аливаа ажил, арга хэмжээнд идэвхитэй оролцох, ажилтан, алба хаагч, багш, ажилчид, оюутан, сурагчдыг шаардлагатай хууль эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах сургалт сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах, мөн тухайн байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээнд цагдаагийн байгууллагаас эрх бүхий албан тушаалтныг тогтмол оролцуулах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал, хэрэг, зөрчилд холбогдсон болон холбогдож болзошгүй этгээдүүдийн талаар харилцан мэдээ, мэдээлэл солилцох талаар ярилцаж, холбогдох сэдвүүдээр 41 алба хаагч 92 байгууллага, аж ахуйн нэгжийн 279 ажилтан, алба хаагчдад мэдээлэл, сургалтыг зохион байгуулаад байна.

Энэ оны эхний улирлын байдлаар хүүхдийн эсрэг болон гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээлэл давтамжтай бүртгэгдэж байгаа эсэхэд дуудлага мэдээллийн ECS болон Цагдаагийн байгууллагын нэгдсэн сангийн Өргөдөл, гомдлын санд судалгаа хийж ажиллалаа. Судалгаагаар тухайн хугацаанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 38 гомдол мэдээлэл бүртгэгдсэнээс давтамжтай буюу 9 этгээдээс энэ төрлийн зөрчилд холбогдсон 2 ба түүнээс дээшхи тохиолдол 24 бүртгэгджээ.

Дээрх тохиолдлуудад дүн шинжилгээ хийж үзэхэд зөрчил үйлдсэн шалтгаан нь ахуйн шинжтэй хэрүүл маргаан, амьжиргааны доогуур түвшиний байдал, эрх зүйн чадвар чадамж муу, өөртөө болон төрийн байгууллагын үйл ажиллагаанд итгэх итгэл сул иргэд байна. Холбогдогч нар нь эрхэлсэн тодорхой ажилгүй, хүүхдийн мөнгөнөөс өөр тогтмол орлогогүй, архины хамааралтай, цагдаагийн байгууллагын судалгаанд бүртгэлтэй байна.

Сүмбэр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ивээл дор Сүмбэр сумын хамтарсан багтай хамтран архидан согтуурах явдалтай тэмцэх, согтуугаар үйлдэгдэх хэрэг зөрчил, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, архины хамаарлыг

таслан зогсоох зорилгоор “Итгэл” төслийг хамтран хэрэгжүүлж, судалгаанд авагдсан болон давтамжтай дуудлага мэдээлэлд холбогдсон нийт 17 иргэн /үүнээс: эмэгтэй 8/-ийг Аймгийн нэгдсэн эмнэлэгт Наркологиин эмчийн хяналтан дор хэвтүүлэн сайн дурын эмчилгээнд хамруулж байна. Эмчилгээнээс гадна Монголын АА нийгэмлэгийн Говьсүмбэр аймаг дахь “Андын хүч” бүлгэмийн сургагч багш, бясалгалын багш нар хичээл, сургалтыг зохион байгуулж, эдгээр иргэдийн нийт 25 хүүхдийг асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт хариуцуулж, Сүмбэр сумын Хамтарсан багаас болон хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс хяналт тавин ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, цагдаагийн байгууллагын судалгаа хяналтын санд бүртгэх, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид тавих нэг бүрчилсэн хяналтыг сайжруулах зорилгоор цагдаагийн байгууллагын “Хүүхэд хамгаалал-2024” ерөнхий арга хэмжээ, аймгийн “Насан туршийн боловсрол төв”-тэй хамтран “Өнөөдрийн зөв үйлдлээр ирээдүйг бүтээнэ” нөлөөллийн аяныг хариуцсан нутаг дэвсгэрт тус тус зохион байгууллаа. Хүүхдийг аливаа хорт зуршлаас ангид байх дадал суулгах, аливаа халдлага, осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, түүнд өртөж хохирохоос сэргийлэх талаар мэдлэг олгох зорилгоор 2 удаагийн хичээл сургалтыг зохион байгуулж, төрийн байгууллага 1, коллеж 1, сургууль 5, цэцэрлэг 7 нийт 14 байгууллагыг татан оролцуулж, 30 ажилтан, албан хаагч, 125 сурагчийг хамрууллаа. Тус аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 0425-р ангиас зохион байгуулсан “Нээлттэй мэдээлэл-Хариуцлагатай алба хаагч” аяны хүрээнд “Хүүхдийн тэтгэлэг гаргуулах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа ба хүүхдийн эрх” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэгт оролцов.

Хүүхдийн нас биеийн онцлогт тохируулж мал ахуйн ажилд оролцуулж туслуулах, аюулгүй байдлыг хангах, хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай ажил хийлгэхгүй байх, морь малтай харьцахад анхаарах талаар хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, уяач нарт зориулж цагдаагийн байгууллагаас 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр 31, 32, 33 дугаар бүхий “Зөвлөмж” бэлтгэн аймгийн морин спорт, уяачдын холбоо, сумдын засаг дарга нарт хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавин хариуг авч ажиллав.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, мэдээлэх зорилгоор цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг нийгмийн сүлжээнд түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, “Сар шинэ-2024”, “Цахим-Архи худалдаа” тусгай арга хэмжээний хүрээнд 1 мэдээлэл, 3 постер бэлтгэж, албаны фэйсбүүк хуудсанд байршуулж, орон нутгийн олон дагагчтай группуудад 358 удаа хуваалцаж, олон нийтэд хүргэсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”, “Гэр бүлийн харилцаа”, “Зөрчлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, “Хар тамхитай тэмцэх” гэх сэдвээр төрийн байгууллага 1, төрийн бус байгууллага 5, нийт 366 ажилчид, алба хаагч нарт замын цагдаагийн тасгийн ахлах мэргэжилтэн, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн нарын хамт 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд ухуулга, яриа, сургалт сурталчилгааны ажлын хүрээнд Аймгийн онцгой байдлын газар, ОНӨААТҮГ-ын Ус-Ду, Чойр өртөө, Төмөр замын барилга ашиглалт үйлчилгээний 3 дугаар анги, Ник Петровис, Шивээ-овоо ххк нийт 6 удаагийн сургалтыг 366 иргэдэд зохион байгуулж ажилласан.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Согтуугаар үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчил, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах зорилгоор албан мэдэгдэл 51 бичиж 38 хариуг авч ажилласан.

“Сар шинэ 2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд байнгын болон түр хяналтын 3 пост, явган болон машинт хөдөлгөөнт эргүүлийн 6 чиглэлд 08:00-15:00, 15:00-23:00, хэв журам сахиулах, замын хөдөлгөөн зохицуулах машинт эргүүлийг 16:00-02:00 цагуудад үүрэг гүйцэтгүүлэхээр хуваарийг хийж давхардсан тоогоор 132 ажилтан, алба хаагч сар шинийн өдрүүдэд эргүүл, постод үүрэг гүйцэтгэлээ.

“Согтуу” хэсэгчилсэн арга хэмжээ: Аймгийн хэмжээнд архидан согтуурах явдалтай тэмцэх, аймгийн Засаг даргын захирамжын биелэлтэд хяналт тавих, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг бууруулах, таслан зогсоох зорилгоор зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд архи согтууруулах ундаа хэрэглэж, хүмүүс ихээр цуглардаг айл өрхийн судалгааг багийн засаг дарга нартай хамтран гаргаж, тэдгээрт архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Зөрчлийн тухай хуулиудаар мэдээлэл, зөвлөгөө өгч, нэгдсэн эргүүл эргүүл шалгалтыг 2 удаа зохион байгуулж ажиллав.

“Эргүүл” хэсэгчилсэн арга хэмжээ: Сүмбэр сумын нутаг дэвсгэрт гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор зохион байгуулж 6 чиглэлд 24 алба хаагч, 162 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж зөрчил гаргасан 21 иргэнийг 325.000 төгрөгөөр торгож, 1 этгээдийг баривчлуулж арга хэмжээ тооцон ажилласан.

Сүмбэр сумын хамтарсан багийн шуурхай хуралд оролцож, хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдол бүрт нөхцөл байдлын үнэлгээг хийх, шаардлагатай мэдээ мэдээллийг харилцан солилцох, дуудлага мэдээлэлд хамтран ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч, коллеж, сургуулийн 5 нийгмийн ажилтнуудад хүүхэд хамгаалал, хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн орчны аюулгүй байдалд анхаарч ажиллах чиглэлээр зааварчилга хүргүүлээ. Цагдаагийн байгууллагаас “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”-ын хэрэгжилтийг хангуулж, коллеж, сургууль, түүний орчин, сурагчдын дотуур байранд тавих хяналтыг аймгийн төвийн 3 сургуулийн нийгмийн ажилтан, эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан “Сургуулийн эргүүл” /School police/-тэй хамтран гүйцэтгэж, тэдгээр орчныг эргүүл, шалгалтын маршрутанд хамруулж, үүрэг гүйцэтгэлд биечлэн шалгалт хийж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллалаа.

Төв байгууллагаас бэлтгэн нийтэлсэн гэмт хэрэг, зөрчил, болзошгүй осол гэмтэл, бусад эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, зөвлөмж, анхааруулга 144, сэрэмжлүүлэг видео шторк 147, цаг үеийн мэдээлэл 125, нийт 417 нийтлэл, алба хаагчдаас бэлтгэсэн санамж, зөвлөмж, анхааруулга 8, сэрэмжлүүлэг видео шторк 2, цаг үеийн мэдээлэл 12, нийт 22 нийтлэл, мэдээллийг албаны фэйсбүүк хуудсанд байршуулан олон нийтэд түгээн 12510 удаа хуваалцаж, 43785 хүнд хүргэсэн байна.

ГУРАВ: ДҮГНЭЛТ

Энэ онд сахилга, ёс зүй, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, алба хаагч, ажилтнуудаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдвэрлэлийн осолд өртөж, хохирсон тохиолдол бүртгэгдээгүй байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажилласнаар гэмт хэргийн илрүүлэлт 55,9 хувьтай байгаа нь урьд оны мөн үеээс 4,0 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

ДӨРӨВ: САНАЛ

Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил, үүргийг хэвийн гүйцэтгүүлэх зорилгоор 24 цагийн ээлжийн орон тоог 4 ээлжээр үүрэг гүйцэтгүүлэх. Үүнд:

- Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч-1,
- Эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүрийн цагдаа 1,
- Жижүүрийн мөрдөгч-1,
- Мэдээлэл хүлээн авагч жижүүрийн цагдаа-1,
- Жижүүрийн жолооч-1,
- Эрүүгийн мөрдөгч 1,
- Зөрчлийн тоо бүртгэгч 1,
- Ахлах зохицуулагч 1,
- Олон улсын чанартай босоо тэнхлэгийн замд үүрэг гүйцэтгэх цагдаа зохицуулагч-4, нийт 12 орон тоог тус тус нэмж батлуулах.

- Алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор анхан, дунд болон давтан сургалтад хамруулах.

- Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрт хамруулах.

ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.БАЯРХҮҮ